



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 5/186

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны
гишүүдийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны даргаар ажиллаж байсан тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Батбаяр өөр ажилд шилжсэн, тус дэд хорооны гишүүнээр ажиллаж байсан Б.Пүрэвжав нь өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан яамны албан хаагчдын санал асуулгын дүнг үндэслэн Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын хэлтсийн дарга С.Жаргалсайхан, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Бат-Ундрал нарыг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилсугай.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-г даалгасугай.

ДАРГА



Д.ОЧИРБАТ

142251186